

# Нүүдлийн соёл иргэншлийн түүхээс



Доктор/Ph/, дэд профессор Ц.Нацагдорж

# Civilization



☞ Civilization хэмээх латин хэлний гаралтай олон улсын тогтсон нэр томъёог монголоор соёл иргэншил хэмээн орчуулж хэвшжээ. Аливаа ард түмний дунд ямар нэгэн соёлын голомт байгаа бол тэнд иргэншил байна гэсэн үг юм. Соёл гэдэг бол суурь ойлголт бөгөөд түүний нийгэмшсэн хэлбэр нь иргэншил юм. Өөрөөр хэлбэл соёл нь анхдагч, иргэншил нь хоёрдогч зүйл агаад хүн төрөлхтөн балар эрт цагаас үүсгэн буй болгосон соёлын олон янзын хэлбэрүүд, хүний нийгэм үүсч хөгжихийн хэрээр түүнтэй уялдан улам бүр нийгэмших болсон байна. Эрдэмтдийн тогтоосноор дэлхий дээр хорь орчим соёл иргэншил байгаа ажээ. Соёл иргэншил нь дотроо дэд бүтцүүдэд, өөрөөр хэлбэл янз бүрийн соёлд хуваагддаг. Тухайлбал, Нүүдлийн соёл иргэншил нь дотроо Хүннүгийн, Сяньбигийн, Хитаны, Монголын соёл гэх мэтээр хуваагдах ба энэ бүгдийн нэгдмэл цогц хэлбэр нь нүүдлийн соёл иргэншил хэмээх нэгэн агуу их **CIVILIZATION** мөн.

# Нүүдлийн соёл иргэншил



- ☞ Манай Монгол судлалд, манай шинжлэх ухааны байгууллагууд, эрдэмтэн судлаачид XIII зуун хүртэлх үеэ эргэн харж нэлээн гүнзгий судалж чадсан хэрнээ түүнээс урагш харж судалж тогтоосон нь харьцангуй бага байна. Харин өнөө үеэс л XIII зуунаас урагшлан балар эртний цаг үеийг хүргэн судалж тодотгохыг цаг үе зүй ёсоор шаардаж байна.
- ☞ Нүүдлийн соёл иргэншлийн үндсийг бид олон янзаар, хэд хэдэн үг хэллэгээр хэлж бичсээр ирсэн билээ. Тухайлбал, Монгол ахуй, монгол аж төрөх ёсон, нүүдэлчин малчин ахуй, малчин ардын ёс, аж төрөл гэх мэт
- ☞ Түүхийн урт удаан цаг хугацааны туршид Төв Азийн нүүдлийн соёл иргэншлийг бүтээлцсэн олон нүүдэлчин угсаатан, ард түмэн байсны зарим нь устаж уусаад, нөгөө зарим нь суурин соёл иргэншилд шилжсэн тул өдгөө нүүдлийн соёл иргэншлийн эртний сонгодог загварыг орхиж гээлгүй авч ирсэн нь бидний монгол түмэн билээ.

# Нүүдлийн соёл иргэншил



᠒ Төв Азийн цээжнээ нүүдэллэн аж төрж асан Түрэг түмэн, Уйгар, Хиргис, Хотон, Тангад, Зүрчид, Манж угсаатан үгүй болоод, харин эртний түүхнээ өдгөөгөөс гурван мянганы тэртээд буюу МЭӨ X зууны үед алдар нэрээ тэмдэглүүлэн үлдээсэн Ху нарын удам Хүн нар/Хүннү/, тэдний удам Сяньби, тэдний удам Кидан, тэдний үр хойчис XIII зууны монголчууд, тэдний үр хойчис болсон XXI зуунд аж төрөгч Та бидний үед хүрч ирэхэд энэ бүхий л он жилүүдийн туршид нүүдлийн соёл иргэншил гэж бахархан нэрлэж буй монгол аж төрөх ёсон огт өөрчлөгдөлгүй явж иржээ. Түүгээр ч зогсохгүй чинагш үргэлжлэн баяжин хөгжих жамтай юм.

# Нүүдэлчин монголчуудын философи



Монголчууд энэ  
гурвал онол салшгүй  
шүтэн барилдлагатай  
байх ёстой гэж үзэж

Байгаль дэлхийгээ  
эх шигээ хайрлан  
хамгаалж,



Хүмүнийг аав  
шигээ дээдлэн  
хүндэтгэж,

Малаа үр хүүхэд  
шигээ өсгөн  
үржүүлж ирсэн  
байна.

# Хүнийг, бусад улс үндэстнийг ТЭГШ ХҮНДЛЭХ ЁСОН



- ☞ Монголчууд эрт дээр үеэс аливаа хэн хүнийг гадна, дотнын гэлгүй тэгш үздэг байсныг “Монголын нууц товчоон” хэмээх алдарт зохиолоос мэдэж болно.
- ☞ *Хүнийг үнэлэх гол үнэлүүр нь* шударгуу зан, эзэндээ үнэнч зүтгэх зүтгэл, ажилсаг хичээнгүй байдал гурав болой. Тэр цагт эзэндээ үнэнч байна гэдэг бол одоогийн ухаарлаар эх орон, **ард түмэндээ хайртай байх** гэдэгтэй адил ойлголт байжээ. Эзэн нь ч гэсэн доорх түшмэл, зарсан элч, албат иргэнээ бусдын халдлага, элдэв доромжлолоос “эзэн шиг” хамгаалж чаддаг, тэр нь ч албат иргэдийнхээ хайр хүндэтгэлийг хүлээдэг байх ёстой. Ер хүний зан шулуун шударгуу, эзэндээ үнэнч бөгөөс дайсан байсан хүнээ ч авч хэрэглэдэг ёсон монголын хаад ноёдын дунд нийтлэг байсан аж.
- ☞ Монголчуудыг зочломхой сайхан зантай, цагаахан тусархаг сэтгэлтэй ард түмэн хэмээн гадаадынхан эртнээс нааш үнэлэн дүгнэж иржээ. Энэ бол харийн хүний сэтгэлд монголчуудын хүрсээр ирсний баримт юм. Энэ мэтчилэн харь гадаад хүнийг хүншээн хүндэлж үздэг монголчуудын үзэл заншил нь бусад үндэстэнд тэгш хандах уламжлалын баримт юм.

# Хүнийг, бусад улс үндэстнийг ТЭГШ ХҮНДЛЭХ ЁСОН



- ☞ Үүнээс гадна ер хүний ухаан билиг, цэцэн цэлмүүн үзэл бодлыг угсаа гарал, шашин суртлыг ялгаварлалгүй жигд анхааран үздэг байсны тод жишээ гэвэл Чингис хаан Елуй Цуцайг төрийн албанд хэрэглэж, Чан чун бумбыг урин авчирч төр ёсны явдлыг хэлэлцсэн түүх даруй мөн.
- ☞ “Усыг нь уувал, Ёсыг нь дага”, “Ёс ёмбогор, төр төмбөгөр” хэмээх үгийг монголчууд чанд бариталдаг байв. Энэхүү ёс, төр гэсэн ойлголтод тухайн ард түмний зан заншил, уламжлал ёс, аж төрөл цөм багтана. Дээрх хоёр үг нь хэн ч болов байж байгаа буюу очсон газар орныхоо хүн ардын ёс төрийг хүндэтгэн дагана гэсэн санаа юм.
- ☞ Дээрх хэдэн мэргэн үгэнд монголчуудын уламжлал заншил бол *олон хэлийн ард түмний ёс төр, зан заншил, шашин шүтлэгийг эрх тэгш хүндэтгэх сэтгэл* нийтлэг, хэн хүнд хүртээмжтэй байсны илрэл ажээ.

# Монголчуудын газар зүйн уламжлалт мэдлэг



- ☞ Монголчууд нэн эртнээс, өвөг дээдсээсээ уламжлан уугуул ус, суугуул энэ нутагтаа гол амьжиргаа болсон таван хошуу малаа адгуулан өсгөж үржүүлсээр ирэхдээ хангай дэлхийнхээ өгөөж шимд шүтэж, аж төрөн суухдаа зөвхөн газар нутгаа сайн мэддэг төдийгүй, дэлхий ертөнцийнхөө байдлыг тандан судалж ирсэн баримт бичиг түүхэнд тэмдэглэн үлджээ.
- ☞ Бидний дээд өвөг Хүннү нар газрын зураг үйлдэн хэрэглэж байсан тухай алдарт жуулчин Марко Поло бичжээ. “...газар зүйг судлахдаа газрын хөрсний дүрэмт сав буюу *газрын ёсны тэмдэглэл*, газрын хөрсний гулдын дүрэмт сав буюу *уртраг тогтоох багаж*, газрын хөрсний хөндлөн дүрэмт сав буюу *өргөрөг тогтоох багаж*, ерэн даруагийн дүрэмт сав буюу *газрын хол ойрыг хэмжих багаж* гэх зэрэг арваад багаж төхөөрөмж хэрэглэж байсныг дурдсан байна.
- ☞ Дүрэмт сав гээд байгаа нь одоогийнхоор бол “хэмжих багаж” гэсэн үг бөгөөд газрын хөрсний дүрэмт сав буюу газрын ёсны тэмдэглэл гэдэг нь ямар багаж байсныг дээрх номд бичсэнээр бол “...*Газрын ёсны тэмдэглэл хэмээх нь модоор дүгрэг бөмбөг үйлдэж долоон хувийг нь ус болгожээ. Үлдэх гурван хувийг газар шороо болгожээ. Түүний өнгө цагаан бөгөөд мөрөн, гол, тэнгис, далай н судсыг түүний дотор хэлхэж тоолжээ. Өчүүхэн зохистой худаг үйлдээд газар дэлхийн агуу ба газрын хол ойрыг тэмдэглэжээ...*”



# Монголчуудын газар зүйн уламжлалт мэдлэг



- ☞ Дээр дурдсанаас үзвэл лавтайяа тэр цагтаа монголчууд эх дэлхийгээ бөөрөнхий гэж мэддэг байсан төдийгүй *дэлхийн арав хуваасны долоон хувь нь ус, үлдэх гурван хувь нь хуурай газар хэмээн бөмбөрцөгт тэмдэглэж байсан нь* өнөөгийн бидний мэдэх дэлхийн бөмбөрцгийн 70,8%-ийг ус, 29,2%-ийг хуурай газар эзэлдэг гэдэгтэй бараг тохирч байгаа нь гайхалтай.
- ☞ Монгол ангуучид Х зууны үест одоогийн Камчатка, Аляска уруу явж *ертөнцийн нөгөө хязгаарыг зорин очдог байсан тухай баримтыг Билгүүн номч Б.Ринчен доктор илтгэлдээ дурдсан байдаг.*
- ☞ Манай ардын дуунд:

... Орчлон гэдэг бөөрөнхий

*Эргэж хөрвөж байдаг...* хэмээсэн үг байдаг. Энэ нь монголчууд эх дэлхийгээ бөөрөнхий бөгөөд эргэж орчиж байдгийг их л эртнээс мэддэг байсан төдийгүй Европ дахинаа ХҮ зууны эцсээр Америк тивийг нээхээс *хэдэн зуун жилийн өмнө Америк тивийг хэдийнээ мэдчихсэн, газар нутгийн хэмжээ дамжаагийн ч нарийн гаргачихсан байжээ.*

Америк тивийн үндсэн хүн ам - Индиана нарын дунд өөрсдийгөө Төв Ази бүр тодруулбал монголчуудтай гарал нэгтэй гэдэг. Соёл заншлын төстэй зүйл ч байдаг нь судлаачдын анхаарлыг татсаар байна.

# Монголчуудын цаг уурын уламжлалт мэдлэг



- ☞ Монголчуудын цаг уурын мэдлэгт *нар, сар, од, мичид, салхины аяс, манан будангийн шинж байдлаар* тэнгэр хангай ямар болохыг шинждэг арга гол байр эзэлдэг. Үүнд: Тэнгэрийн хаяа улайж нар шингэвээс маргааш сайхан өдөр болно, салхи урдаасаа уривал тэнгэр эвгүйтнэ, нар сар хүрээлвэл хүйтэрнэ гэх мэт
- ☞ Мөн *таван хошуу мал, араатан гөрөөс, жигүүртэн шувуу, хорхой шавж зэрэг* амьтны байр байдлыг ажиглаж тэнгэр ямар болохыг шинжих нь монголчуудын дунд өргөн дэлгэрчээ. Тухайлбал, Тэнгэр муухай байхад унага, тугал эрхлэн гүйвэл онгойхын тэмдэг, хараацай шувуу дээгүүр нисвээс тэнгэр сайхан байх, доогуур нисвээс эвгүйрхэхийн тэмдэг, чонын от ороо эрт эхэлвэл ирэх хавар зөөлөн орохын шинж гэх мэт
- ☞ Үүнээс гадна *эд юмс хийгээд утаа гарах байдал, мөн газар орны шинж төлөвөөр* тэнгэр ямар болохыг зөгнөн мэддэг байна. Жишээлбэл, салхигүй намуун үед яндангийн утаа эгц дээшээ гарч байвал тэнгэр сайхан байх, давс чийгтэх, гаанс бөглөрч бохь нь шаржигнах, гэрийн хялгасан бүслүүр, оосор бүч чангарч чивчирэх нь цөм оэнгэр муудах, бороо орохын тэмдэг гэх мэт
- ☞ Тэр ч байтугай *амьдралын хатуу хүтүүг биеэрээ туулж насан өндөр болсон өтгөс өвгөд биеэрээ тэнгэр болохыг зөгнөн мэдэж* ажил төрлийг нь заан зурдаг. Тухайлбал, бие нозоорч залхуу хүрэх, үе мөчөөр өвдөх, бэртэнгэтэй бөгөөд тэр нь өвдвөл тэнгэр муухайрахын шинж гэх мэт

# Монголчуудын цаг уурын уламжлалт мэдлэг

- ☞ Монголчууд зөвхөн өнөө маргаашийн тэнгэрийн байдлыг хэлээд зогсохгүй, зун, намар бол *өвс ургамал, самар жимсний гарц болцоор*, өвөл бол *цас мөсний онцлогоор, бас ан амьтан, араатан жигүүртний ичих, буцах, хөөө тэжээлээ цуглуулах байдал зэрэг* олон онцлогийг ажиглаад ирэх жил, улирал ямар болохыг зөгнөн мэдэж нүүдэл буудлаа тохируулан зохицуулдаг уламжлалтай
- ☞ Аж амьдралын арвин их туршлагаар үнэн зөв нь шалгарсан мэдлэгийг хойч үедээ уламжлан үлдээхийн *тулд хэн бүхэнд ойлгомжтой, цээжлэхэд хялбархан, өдөр тутмын аж төрөлд хэрэглэгдэх сургаалын чанартай зүйр цэцээн үгэнд шингээж хэлэлцдэг ёс заншил бий. Тухайлбал,*
- ☞ ...Өглөөний нарыг наранд бүү бод  
Өсөхийн жаргалыг жаргалд бүү бод  
Ширүүн бороо уддаггүй  
Шиврээ бороо уддаг  
Дуутай тэнгэр хургүй  
Цуутай хүүхэн хуримгүй  
Үүл сөрвөл бороо  
Үг сөрвөл хэрүүл  
Орох тэнгэрийн орой цоорхой  
Орсон буурын шил цоорхой.... гэх мэт

# Монголчуудын цаг уурын уламжлалт мэдлэг



- ☞ Монголчуудын дунд *тэнгэр задраах, тэнгэр хангай хилэгнэх* гэх зэрэг сонин хэллэг олон байдаг. Тэнгэр задраана гэдэг нь цаг улиралдаа үл зохилдох зүйл үйлдсэнээс үүдэж тэнгэр хангай эвгүйрхэнэ гэсэн үг. Тэнгэр хангай хилэгнэнэ хэмээх нь аливаа ёсон бусын зүдэг хар үйл үйлдэх, орон дэлхийг зүй бусаар хөндөх зэргээс болж *хариу цээрлэл үзнэ гэсэн санаа юм*.
- ☞ Энэ бол нутаг ус, хангай дэлхийгээ хайрлан хамгаалж, *уугуул унаган төрхөөр нь байлгах* гэсэн эрхэм сайхан уламжлалт ёс заншил болсон зүйл юм.
- ☞ Дээр өгүүлсэн бүх зүйл нь монголчууд нэн эрт цагаас байгаль дэлхийн явдал, цаг уурын үзэгдлийг зөв танин мэдэж аж төрлөө түүнд зохицуулан тохируулж ирснийг товч өгүүлэхэд ийм байна. Нөгөө талаар монголчууд тэнгэр хангай, орон дэлхийгээ дээдлэн шүтэж, хайрлан хамгаалж өдөр тутамдаа байнга харилцаж, аж төрлөө зохицуулан олон мянган жил амьдарсаар ирсний нотолгоо юм.

# Монголчуудын мал маллагааны уламжлалт арга



- Эртний судлалын эд өлгийн хэрэглэгдэхүүнээс үзвэл чулуун зэвсгийн үеэс бидний өвөг дээдэс энэ уугуул нутаг газар дээрээ мал сүргээ адгуулан өсгөж малынхаа аз занг даган *нүүдэллэн аж төрж ирсэн нь монголчуудын амьдралын өвөрмөц хэв маягийг бий болгожээ*. Мал нь ч гэсэн ус нутагтаа идээшин ээнэгшиж яв явсаар *нэгэн онцлог шинж төлөвийг олсон нь* суурьшмал газрын мал сүргээс ихэхэн ялгавартай болгожээ.
- Монгол малын бие чац, сүү шим нь малынхаа хувьд ч, эзнийхээ хувьд ч хээрлэн бэлчиж өсч үрждэгтэй нь нарийн зохицсон байдаг. Малчид ч олон жилийн амьдрал туршлагаараа идэж уух, өмсч зүүх, эдэлж хэрэглэх зүйлээ хангаж чадахуйц, бас нутаг усандаа зохицсон *малын үүлдэр угсааг бий болгож чадсан байна*.

# Монголчуудын мал маллагааны уламжлалт арга

- Эрт цагаас монголчууд *мал малын захтай байхыг* эрхэмлэдэг байсан нь таван хошуу мал сүрэг *бие биесийн хүчинд шүтэж өсөн үрждэг ажээ*. Тухайлбал, цас зудтай үед бод мал нь бог малдаа *зам чийр гарган өгдөг*, үхэр өөрөө бууц тарьдаггүй болохоор хонь ямааныхаа тарьсан *бууцны хөлөөр шөнө тавтай хэвтдэг*, хүйтэн хошуутай ямаа, *хониныхоо нөмөр нөөлөгт шөнийг дулаан өнгөрөөдөг* гэх зэргээр бие биедээ дулдуйдан өсч үржиж *мал малын зах нь нэгэн цогц болдог ажээ*.
- Ийнхүү манай *малчин ард түмэн маань* нутаг орон, байгаль цаг ууртаа бүрэн зохицсон, нүсэр их хөрөнгө, хүч шаарддаггүй, дөрвөн цагийн туршид бэлчээрлэн тааваараа өсдөг *нутгийн малыг буй болгож чадсан байна*.

# Монголчуудын мал маллагааны уламжлалт арга



- ☞ Бэлчээрийн мал маллагааны ажил нь малчин монголчуудыг хүн хүчээ нэгтгэж, хамтран ажиллах өвөрмөц олон хэлбэрийг буй болгож тэр нь улмаар хувиа бодсон аминч бодлыг монгол хүний сэтгэл санаанаас зайлуулан холдуулж *“Айл хүний амь нэг, саахалт хүний санаа нэг”* гэсэн нийтэч үзэл санаа хэвшил болжээ.
- ☞ Ийнхүү хамтран ажиллах өвөрмөц арга нь *хот айл, саахалт, нэг голынхон* гэх зэрэг олон хэлбэрийг бий болгож, тэдгээр нь *хүн хүч хэмнэх, хүчир хөдөлмөрийг хөнгөвчлөхөд чиглэж* байснаас гадна *хамтын хөдөлмөрийн баяр баясгалан болдог байжээ.*
- ☞ Хот айл буюу хотыг бүтцээр нь авч үзвэл:
  - *ганцаараа хот болж явдаг аж ахуйтан.* Ийм хот нь мал сүргээ өсгөж үржүүлэх, аж ахуйгаа хөтлөх хүн бүлтэй байдаг
  - *малын тоогоор ойролцоо хэдэн өрхөөс бүрдсэн хот айл*
  - *малын тоогоор адилгүй хэдэн өрхөөс бүрдсэн хот айл*

# Монголчуудын мал маллагааны уламжлалт арга



- ☞ Саахалт айлуудын тухайд *саах тавина гэдэг сайхан ёс байсан* нь саалийн үед хүн хүч хэмнэж хамтран ажиллах нэгэн өвөрмөц хэлбэр байлаа. Саах тавих гэдэг нь саахалт хоёр хот айлынхан хурга ишгээ *саалийн үед зөрүүлэн* хариулж хүн хүчээ хэмнэхийг хэлнэ.
- ☞ *Цагийн хатууд мал оторлоно* гэдэг нь мөн л хот, саахалтаараа эр сувай малыг нийлүүлэн авч *хатуу цагийн бэлчээр хэмээн нөөн хадгалж байсан* нутаг бэлчээрээ ашиглаж, мөн л хүн хүч хэмнэхийг хэлнэ
- ☞ Малчин ард олны хамтын ажиллагааны бас нэг хэлбэр нь *нэг голынхон* юм. Гүү барих, хонь хяргах, эсгий хийх, хурга ишиг хөнгөлөх зэрэг айл хот болгонд тохиолдох ажлыг *хот, саахалт, нэг голоороо хамжин хийж ирсэн нь чухамдаа хамтын хөдөлмөрийн баяр баясгалан болж байв.*
- ☞ Хот айлаараа, айл саахалтаараа, нэг голоороо хийж байгаа хамтын хөдөлмөрийн баяр цэнгэл нь *нарийн журам, уламжлалт дэг ёстой болж, тэрхүү зан үйл нь малчин хүн бүрийн санаа сэтгэлд нийцсэн баяр ёслол болжээ.* Энэ бүхнээс үзвэл, аливаа ард түмний өвөрмөц уламжлал, зан заншил нь эрхэлдэг аж ахуй, тэрхүү аж ахуйгаа хөтлөх арга хэлбэр зэрэгтэй шүтэн барилдсан байдаг байна.



# Монголчуудын мал маллагааны уламжлалт арга



- ❧ Жилийн дөрвөн улиралд өвсний соргог, усны тунгалагийг хөөж таван хошуу малаа адгуулан өсгөх нь *нүүдэл хийж аж төрөх хэлбэрийг шаардан нөхцөлдүүлжээ.*
- ❧ Энэхүү *нүүдэл нь* хангай говийн ялгаа, цаг улирал, нутаг бэлчээрийн хүрэлцээ, малын тоо толгой, ус ундны байдал, хүн малын өвчин зовлон, хужир давсны шаардлага гэх зэрэг өдий төдий хүчин зүйлтэй уялддаг байна.
- ❧ Монголчуудын нүүх ёсыг судалсан гадаад, дотоодын эрдэмтдийн судалгаанаас үзвэл, хангай газар 10 орчим, говь нутагт 10-14 удаа нүүдэлдэг байна.
- ❧ Эрдэмтэн Ц. Балхаажав “...Монголын малчны үүх түүх наад зах нь шинэ чулуун зэвсгийн үеэс, түүнээс өмнөх үеэс ч улбаатай байж магадгүй. Монгол орныг нуруундаа үүрч яваа мал, малчин хоёр маань лавтай 500, магадгүй 1000 жилийн урт түүхийг ардаа орхисон. Дундажаар 45-50 насны 200-аад үеийн малчин удам бий...” гэж бичсэн бөгөөд үүнтэй ойролцоо буюу ижил санал дүгнэлтийг доктор Ч.Батсуурь, Д.Наваан, Н.Сэр-Оджав, Н.Ишжамц Оросын Ю.Г.Рычков, Өвөр Монголын Тогтох, Алтан-Оргил зэрэг эрдэмтэд бичсэн байна.

# Таван хошуу малын ааш араншин, сэтгэл зүйтэй холбоотой монголчуудын мэдлэг



- ☞ Таван хошуу мал сүргээ адгуулан маллаж өнө удаан аж төрөх явцдаа *монголчууд малынхаа ааш араншин, сэтгэл зүйг аажим аажмаар танин мэдсээр нэгэн бүхэл бүтэн цогц мэдлэгийг хуримтлуулж*, мал аж ахуйг эрхлэн хөтлөх үйл ажиллагаандаа малынхаа ухаан араншинг *хөтлөн жолоодох шатанд хүрчээ*.
- ☞ Малын ухаан гэдгийг хэдийгээр хүнийхтэй зүйрлэхийн аргагүй боловч монгол хүлэг морь эзнээ хээр орхиж явгалдаггүй, уралдааны замд ямар ч зайгүй байлаа гэхэд унаж ойчсон хүүхэд дээр гишгэдэггүй, монгол мал төрсөн хот хороо, ижил сүрэг, ус нутгаа санаж хаа холоос ч гүйж ирдэг, уртын дуу хуурдахыг сонсоод уяран хайлж нулимс бөмбөрүүлдэг, эмнэг догшин мал эзнийхээ дууг сонсч барааг нь хармагцаа номхрон гарынх нь аяар болдог зэрэг олон ааш араншинг хэтэрхий сайн мэддэг монголчууд *мал сүргээ “ухаантай амьтан” гэж ямагт хайрласаар ирсэн*.
- ☞ Хурдан морь унаж яваа хүүхэд нь *“гийн гоо”, “ум марзай” “Зээ хөө”* зэрэг тусгай ая дууг нарийн цээл хоолойгоор аялахад хурдан морины ааш араншинг эрмэгшүүлж, хөлий нь хөнгөрүүлж өгдөг билээ.

# Таван хошуу малын ааш араншин, сэтгэл зүйтэй холбоотой монголчуудын мэдлэг



- ☞ *Гологдсон буюу өнчин төл авахуулах зан үйл* нийт монголчуудын дунд ерөнхийдөө нийтлэг байдалтай боловч монгол нутаг өргөн уудам болохоор нутаг нутгийн онцлог наад зах нь ая дан дээр ч байдгийг судлаачид тэмдэглэсэн нь бий.
- ☞ Төл авахуулахад хэрэглэдэг дуу хөгжмийн зүйлийг дотор нь *дан хөгжмийн зүйл, дан дууны зүйл, хоршмол зүйл гэж хуваан үзэж болно*. Хөгжмийн тухайд морин хуур, лимбэ, цоорыг эрхэмлэнэ. *Дууны тухайд тухайн эх малыг учирласан, гуйсан, айлгасан утга бүхий тусгай дуу байхаас гадна уртын дуу байж болно*. Тэгэхдээ таван хошуу мал болгоны онцлогт тохирсон дуу дуулж хуурдана. Хонийг *тойглох*, ямааг *чээглэх*, үнээг *өөвлөх*, ингийг *хөөслөх* ба ая дуундаа тохирсон үгтэй байдаг. Гүүг ихэнх газар *гурийлна*. Бас морины тухай уртын сайхан дууг хуурдаж дуулна.

# Таван хошуу малын ааш араншин, сэтгэл зүйтэй холбоотой монголчуудын мэдлэг



- ☞ Монгол малчин хүн бүр дуулж хуурдан гологдсон төлий нь эхэд нь авахуулдаг боловч ийм ажилд нарийн мэргэшсэн хүмүүс бусдаасаа ялгаран гарч, *тэднийг нутаг орныхон нь урьж залж гологдсон буюу өнчин төл авахуулах зангил ёслол байдаг*. Ийнхүү мэргэшсэн хүмүүс ямар ч адармаатай малын аяыг олж аргадаа оруулах идтэй, эрдэмтэй байсан тухай домог мэт яриа нутаг бүрт байдаг.
- ☞ *Өнчин буюу гологдсон төлийг өөр аргаар тухайлбал, аливаа эх амьтанд байдаг үр төлөө хайрладаг төрөлхийн зөн билгийг нь сэдээх аргаар голсон эхэд нь буюу өөр эхэд авахуулдаг заншил бас бий*. Тухайлбал, Эхийнх нь нүдэн дээр голсон төлд нь нохой ойртуулах, хөдөө хээр хоёулхныг нь уяж дасгах зэрэг олон арга хэрэглэдэг байлаа. Бас төлөө үхүүлсэн эхэд өөр төл авахуулж хөхүүлэхдээ үхсэн төлийнх нь арьсыг хөхүүлэх, сүүгий нь түрхэх, эс бөгөөс мөнөөх төлд нь хужир давс түрхэж долоолгон ойртуулсаар дасгадаг арга байсан байна

# Монгол тооны ухаан



- ☞ Тоо бодлогын хүрээнд гар хуруугаар тоолон сурахаас эхлээд цээжээр бодох, сампингаар бодох, зурж бодох, зурхайн самбар дээр бодох зэрэг аргад багачуудыг сургадаг байжээ. Тухайлбал, “9 арилгах”, “27 арилгах”, “67 арилгах”, “707 арилгах” зэрэг монгол зурхайн анхны дадлага олгох аргыг заадаг уламжлал тогтсон байжээ.
- ☞ Монгол хэлний үгийн санд тоозүйн холбогдол бүхий эх тоо, хүү тоо, төв хөвч/косинус/, өлгүү хөвч /синус/, өлгүү шахах хямцаа /тагенс/, төв шахах хямцаа /котагенс/ гэх зэрэг олон нарийн нэр томъёо уламжлагдсаар ирсэн нь монголчуудын тооны ухааны мэдлэгтэй холбоотой билээ.
- ☞ Монголчууд тооны нэрийг аравтын тогтолцоогоор нэг, арав, зуу, мянга, түм, бум, сая, живаа, дүнчүүр гэх зэргээр 10-ын б6 зэрэгтэй тоог нэрлэдэг тусгай нэртэйгээр онцлог юм.
- ☞ Монголчууд нас насанд нь тохирсон “Хошин бодлого”-ын арвин баялаг сантай ард түмэн юм. Жишээлбэл, *Хэсэг галуу нисч явтал нэг галуу дайралдаад “Зуун галуу сайн явж байна уу” гэхэд тэдний нэг нь “Бид зуу биш ээ, Бидэн дээр биднийг нэмээд, түүний дээр нь бидний хагасыг нэмээд, бас хагасын хагасыг нэмж, дээр нь чамайг нэмбэл сая зуу болно” гэжээ. Хэдэн галуу нисч явсан бэ?*

# Монгол зурхай



- ☞ Монгол зурхайн ухаанд энэтхэг, төвөдийн эрдэмтэн мэргэдийн зохиол бүтээлээс гадна нангиадын зурхайн гол бүтээл “Хас хуурцаг нэрт бичиг”, “Солбицон барих бодрол бичиг” гэдэг номыг орчуулан хэрэглээд зогсохгүй, нарийвчлан боловсруулж өөрийн орон нутагтаа тохируулан хэрэглэдэг байжээ.
- ☞ Монголын тоозүйч, зурхайч эрдэмтдийн бүтээл, онол нь гол төлөв төвөд хэлээр байсан тул Төв Азийн олон ард түмний оюун билгийн их өв санд багагүй нөлөө үзүүлсэн гэдгийг франц, хятад, японы эрдэмтэд ном зохиолдоо тэмдэглэжээ.
- ☞ Монголын эрдэмтэн их тоозүйч Ш.Мянгат/1685-1770/европ дахины их эрдэмтэн Н.Коперник, И.Ньютон, И.Кеплер нарын бүтээлийг судалж Дорнодахинд танилцуулснаас гадна тоозүйн салбарт “Тоозүйн хуулийн нарийн хуримтлал”, “Тойргийг огтолж II тоог олох хялбар арга”, одон орны судалгаагаар “Цаг улирлын үзэгдлийг шалгаж бүтээсний дараах найруулал” зохиолоо туурвисан нь Дорнодахины тоо, одон зүйн ухаан хөгжихөд ихээхэн нөлөө болсон гэж судлаачид үздэг.
- ☞ Сүмбэ ханбо Ишбалжир/1704-1788/монгол зурхайн уламжлалд шинэ онол үүсгэж гараг, одны явдлыг шинжлэн судлах өвөрмөц аргыг нээсэн зохиолоо туурвисныг түүний дараачийн зурхайч нарын бүтээлээс мэдэж болно.

# Монголчуудын уламжлалт

## цаг тоолол



☞ Монгол ардын аман зохиолд аливаа үйлийг үйлдэхдээ:

“...сарын сайныг саатан хүлээж

өдрийн сайныг өнжин хүлээж

өлзий учрал бүрдсэн энэ өдрийг сонгож...” гэж өгүүлсэн нь нэн олон бий. Үүнээс үзэхүл тухайн зан үйл хийгээд од мичдийн тохиолын шүтэлцээ холбоог маш сайн мэддэг байсныг гэрчилж байна.

Бидэнд мэдэгдэж буй баттай баримтаар монгол газар шашин ном гурвантаа дэлгэрэхээс бүр өмнө Хүннү улсын үед МТӨ III-I зуунд сар сарын тодорхой хэдэн өдрийг эрхэмлэдэг байсан тухай түүхэнд тэмдэглэн үлдээжээ. Ингэж өдөр, цагийг сонгон үздэг байсан нь нэг талаас одон зурхайн уламжлалт ухаантай, нөгөө талаас нүүдлэн аж төрж, ажил төрлөө аль илүү зохистой, бүтэмжтэй өдөр, цагт нь бүтээх гэсэн шаардлагатай холбоотойгоор үүссэн байна.

Монголчуудын зурхайн ухаан буюу одот ертөнцийн шүтэн барилдлагыг судлах ухааны хөгжилд

Юань улсын үе онцгой үүрэг гүйцэтгэсэн бөгөөд Монголын их хааны ордноо тэр цагтаа нэр цууд гарсан тоозүйч, одонзүйч, зурхайч зэрэг олон эрдэмтэн мэргэд Ази, Европын олон улс орноос уригдан ирж хуран чуулж, ном эрдмийн мөр хөөж байсан тухай “Юань улсын судар” хийгээд Марко Поло зэрэг жуулчдын тэмдэглэлд үлдсэн байдаг.

# Монголчуудын уламжлалт

## цаг тоолол



Монгол цаг тооллын тогтолцооны хамгийн их нэгж нь галав бөгөөд хамгийн бага нэгж нь дэнс буюу 9-10 хором буюу нарийн хувь болно.

Монгол цаг тооллын тогтолцоо нь:

Галав /толь галав, эвдэрхүй галав, хоосон галав, тогтох галав, орших галав, их галав/

Жаран буюу их мөчлөг

Арван хоёр жил буюу бага мөчлөг

Жил

Улирал буюу цаг

Сар

Уур хэм /15хоног/

Долоо хоног

Хоног

Цаг

Мөч/24 мин/

Чинлүүр/24 сек/

Амьсгал/4 сек/

Эгшин/0,06 сек/

Дэнс/9.10 сек/

